



ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ БАРАА ЭРГЭЛТ, ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛ

Монгол Улсын гадаад худалдааны эргэлт 11.3 тэрбум ам.долларт хүрлээ.

2011 оны урьдчилсан байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 11,307.2 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 83.1%-иар өсчээ. Нийт бараа эргэлтийн 56.0% буюу 6327.5 сая ам.долларын худалдааг Хятад улстай, 14.9% буюу 1691.9 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна.


Импорт хурдтай өссөөр...

Тайлант хугацаанд нийт экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 64.9%-иар өсч 4780.4 сая ам.долларт, импорт 99.1%-иар өсөн 6526.9 сая ам.долларт тус тус хүрчээ. Импортын өсөлтийн хурд экспортынхоос 1.5 дахин илүү байснаар нийт гадаад худалдааны алдагдал 1746.5 сая ам.долларт хүрэв. Үүнээс валютаар төлбөр нь хийгддэг барааны гадаад худалдааны алдагдал 409.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 5.4 дахин өсөөд байна.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс 12 дугаар сард буурлаа.

2011 оны 12 дугаар сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс¹ 1.636-д хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.0%-иар буурсан байна. Гадаад худалдааны нөхцөлийн индексийн бууралтад импортын машин тоног төхөөрөмж, нефтийн бүтээгдэхүүний үнийн индексийн өсөлт голлон нөлөөлжээ.

Зураг 2. Худалдааны нөхцөлийн индекс, сараар




Хүснэгт 1. Гадаад худалдааны эргэлт /сая ам.доллар/

	Эхний 12 сар		Δ%
	2010	2011	
Гадаад худалдааны нийт бараа эргэлт	6 177,1	11 307,2	83,1%
▪ Валютын төлбөртэй бараа	5 867,2	9 948,3	69,6%
Экспорт	2 899,2	4 780,4	64,9%
▪ Валютын төлбөртэй бараа	2 895,7	4 769,5	64,7%
Импорт	3 277,9	6 526,9	99,1%
▪ Валютын төлбөртэй бараа	2 971,5	5 178,8	74,3%
Гадаад худалдааны тэнцэл	-378,7	-1 746,5	4,6x
▪ Валютын төлбөртэй бараа	-75,9	-409,3	5,4x

Эх сурвалж: ГЕГ

Зураг 1. Гадаад худалдааны эргэлт, сараар /сая ам.доллар/



Зураг 3. Худалдааны нөхцөлийн индексийн жилийн өөрчлөлт



ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА, ТҮҮХИЙ ЭД²

¹ Экспортод дунджаар 90 орчим хувийг эзэлдэг 10 бүтээгдэхүүн, импортод дунджаар 88 орчим хувийг эзэлдэг 7 бүлэг бүтээгдэхүүний хувьд худалдааны нөхцөлийн индексийг 2000 оныг суурь болгон тооцов.

² Экспортын үнэ нь худалдааны түнш хооронд гэрээгээр тохирсон болон бүс нутгийн зах зээл дэх үнийг илэрхийлнэ.

Чулуу нүүрсний экспорт нийт экспортын 46.8 хувийг бүрдүүлж байна.

2011 оны урьдчилсан байдлаар нийт 4780.4 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 64.9% буюу 1881.2 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Мөн хугацаанд нийт экспортын 46.8%-ийг чулуу нүүрс, 20.1%-ийг зэсийн баяжмал, 9.1%-ийг төмрийн хүдэр ба баяжмал, 5.2%-ийг боловсруулаагүй нефть тус тус бүрдүүлж байна. “Бороо Гоулд” ХХК 2106.8 кг алтыг Канад улс руу, Хадгаламж банк 150.8 кг алтыг БНСУ руу, 397.8 кг алтыг Швейцарь улсад тус тус экспортолсон байна.


Мөнгөжөөгүй алт, молибдений хүдэр ба баяжмал, ямааны угаасан самнасан ноолуурын экспортын биет хэмжээ буур-

снаар нийт экспорт 128.4 сая ам.доллараар буурахаар байсан боловч (i) чулуу нүүрс, (ii) төмрийн хүдэр, (iii) боловсруулаагүй нефть, (iv) жонш, лейцит, нефелинт сиенитийн биет хэмжээний өсөлтөөс шалтгаалан 434.9 сая ам.доллараар, эдгээр бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүний экспортын үнийн өсөлтөөс шалтгаалан 1520.4 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс өсөхөд нөлөөлжээ.

Экспортын түүхий эдийн үнэ буурч байна.

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдөр унц тутамд 1572.4 ам.долларт хүрсэн нь оны эхнээс 11.7%-иар өссөн бол, өмнөх сараас 7.8%-иар буурсан байна. Харин А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 7590.0, 1827.3 ам.долларт хүрч, оны эхнээс тус тус 21.1%, 25.7%-иар буурсан байна.

Зураг 5. Лондонгийн металлын бирж дэх зэс, цайр болон дэлхийн зах зээл дэх алтны үнэ /ам.доллар/



Эх сурвалж: Bloomberg


Өвөрмонголын зах зээл дэх нүүрсний дундаж үнэ 2011 оны 12 дугаар сарын байдлаар тонн тутамд 114.7 ам.долларт хүрч оны эхнээс 1.5 дахин өссөн байна. Харин Монгол Улсын экспортын нүүрсний хилийн дундаж үнэ тонн тутамд 114.2 ам.долларт хүрч оны эхнээс 1.9 дахин өссөн бол өмнөх сараас 4.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Нэр төрөл	Эхний 12 сар				Монгол дунгийн өөрчлөлт /хувиар/
	2010		2011		
	Хэмжээ /тн, баррель/	Монгол дүн	Хэмжээ /тн, баррель/	Монгол дүн	
1 Чулуун нүүрс	16 559 009	874.6	20 956 065	2 239.3	156.0% ↑
2 Зэсийн баяжмал	568 664	770.6	572 791	963.6	25.0% ↑
3 Төмрийн хүдэр ба баяжмал	3 539 320	250.9	5 753 124	437.3	74.3% ↑
4 Боловсруулаагүй нефть	2 078 682	154.9	2 540 475	252.2	62.8% ↑
5 Цайрын хүдэр ба баяжмал	119 789	134.1	120 724	142.7	6.4% ↑
6 Ямааны угаасан ноолуур	3 016	104.6	2 830	131.9	26.1% ↑
7 Мөнгөжөөгүй алт	5 060	178.3	2 655	113.0	-36.6% ↓
8 Жонш, лейцит, нефелинт ба	376 049	63.2	404 001	94.9	50.2% ↑
9 Ямааны самнасан ноолуур	977	68.8	538	57.6	-16.2% ↓
10 Молибдений хүдэр ба баяжмал	4 768.7	52.0	4 191.0	46.4	-10.8% ↓
Бусад		247.1		301.3	22.0% ↑
Нийт экспорт		2 899.2		4 780.4	64.9% ↑

Эх сурвалж: ГЕГ

Зураг 4. Экспортын өөрчлөлт дэх үнийн болон тоо хэмжээний нөлөөлөл /сая ам.доллар/



Эх сурвалж: ГЕГ

Зураг 6. Чулуун нүүрсний зах зээлийн үнэ /ам.доллар/




Эх сурвалж: ГЕГ, ЭБЭХЯ

Импортын өсөлт үргэлжилсээр...

2011 оны урьдчилсан гүйцэтгэлээс нийт импорт 6526.9 сая ам.доллар болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 2.0 дахин буюу 3249.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд: i) хүнд машин, механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт 2.1 дахин өсч 1167.3 сая ам.долларт, ii) нефтийн импорт 1.7 дахин өсч 1134.9 сая ам.долларт, iii) тээврийн хэрэгслийн импорт 2.5 дахин өсч 1074.5 сая ам.долларт тус тус хүрсэн нь голлон нөлөөлжээ.


Нийт импортын 79.3% буюу 5178.8 сая ам.долларыг валютын төлбөртэйгээр, 18.3% буюу 1194.5 сая ам.долларыг хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа эзэлж байна.

Зураг 7. Монгол улсын нефтийн импорт, хилийн дундаж үнэ



Эх сурвалж: ГЕГ

Зураг 8. Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ



Эх сурвалж: Bloomberg

Дүгнэлт: Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2011 оны урьдчилсан байдлаар өмнөх оны мөн үеэс 83.1%-иар өсөхөд экспортын гол нэрийн 10 бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 57.3%-иар, импортын гол нэрийн бараа, түүхий эдийн биет хэмжээ 51.7%-иар өссөн нь голлон нөлөөлөв.

Хүснэгт 3. Импортын барааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Нэр төрөл	Эхний 12 сар		Өөрчлөлт /хувиар/
	2010	2011	
1 Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	546,2	1 167,3	113,7% ↑
2 Нефтийн бүтээгдэхүүн	678,0	1 134,9	67,4% ↑
3 Тээврийн хэрэгсэл	422,2	1 074,5	154,5% ↑
4 Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	114,2	212,3	85,8% ↑
6 Хүнсний бүтээгдэхүүн	168,9	189,2	12,0% ↑
7 Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо	63,5	90,5	42,5% ↑
5 Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	22,8	58,0	154,5% ↑
8 Төрөл бүрийн даавуу	1,7	1,8	9,3% ↑
9 Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	124,2	211,3	70,2% ↑
Бусад	1 136,2	2 387,1	110,1% ↑
Нийт импорт	3 277,9	6 526,9	99,1% ↑

Эх сурвалж: ГЕГ

Нефтийн хилийн дундаж үнэ өсөж байна.

Тайлант хугацаанд Монгол Улсын нефтийн импортын биет хэмжээ өнгөрсөн оноос 21.7%-иар, хилийн дундаж үнэ 35.2%-иар тус тус өссөнөөр нийт импорт мөнгөн дүнгээр 1134.9 сая ам.долларт хүрчээ.

Нефтийн импортын хилийн дундаж үнэ 2011 оны 12 дугаар сард тонн тутамд 1240.4 ам.долларт хүрснээр оны эхнээс 34.1%-иар, өмнөх сараас 0.2%-иар тус тус өсөд байна.

Түүнчлэн, 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дэлхийн зах зээл дээрх Brent маркийн газрын тосны үнэ баррель тутамд 108.7 ам.долларт хүрч өмнөх сараас 3.4%-иар, WTI газрын тосны үнэ баррель тутамд 98.8 ам.долларт хүрч өмнөх сараас 1.5%-иар тус тус буурсан байна.